МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 16 өдөр Дугаар А/150 Улаанбаатар хот

**Хууль зүй, дотоод хэргийн яамны "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө" батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар батлсугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-д даалгасугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд /С.Баатаржав/-д үүрэг болгосугай.

Х.НЯМБААТАР

Файл. Сайд тушаал. 2021

151300495

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны 01 дугаар сарын 4-ны өдрийн
A/50 дугаар тушаалын хавсралт

# ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ "2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ"

2021 ОН

## ГАРЧИГ


НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ..................................................4-5

ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ ..................................................6-9

ГУРАВ.АЛСЫН ХАРАА ..................................................9

ДӨРӨВ.ЭРХЭМ ЗОРИЛГО ..................................................10

ТАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ ..................................................10-11

ЗУРГАА.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ..................................................12

ДОЛОО.СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ ..................................................13-22

НАЙМ.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ ..................................................23-24

ЕС.ХАВСРАЛТ ..................................................

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ЗГХЭГ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ЗХХАХБХ | Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэс |
| ЭЗХ | Эрх зүйн хэлтэс |
| ХОТХ | Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтэс |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ХХЕГ | Хил хамгаалах ерөнхий газар |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| АЕГ | Архивын ерөнхий газар |
| ГИХГ | Гадаадын иргэн, харьяатын газар |
| ШШҮХ | Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн |
| ДХИС | Дотоод хэргийн их сургууль |
| ХЗҮХ | Хууль зүйн үндэсний хүрээлэн |
| ХЗТТ | Хууль зүйн туслалцааны төв |
| ТТАХНЭ | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг |
| ОӨГ | Оюуны өмчийн газар |
| МУГХУСАЗЗ | Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл |
| МХХ | Монголын хуульчдын холбоо |
| МНТ | Монголын нотариатчдын танхим |
| МӨХ | Монголын өмгөөлөгчдийн холбоо |
| ТЕГ | Тагнуулын ерөнхий газар |
| УЕПГ | Улсын ерөнхий прокурорын газар |
| ТББ | төрийн бус байгууллага |
| ОУБ | олон улсын байгууллага |

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**Зорилго, зорилт.** Энэ төлөвлөгөөний зорилго нь Хууль зүй, дотоод хэргийн яамны хөгжлийн хандлага, 2021-2024 онд баримтлах стратегийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг тогтооход оршино.

Уг зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж, төлөвлөгөөнд тусгасан:

- Хууль зүй, дотоод хэргийн яамны өнөөгийн тулгамдсан асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх;
- Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийх, ерөнхий чиг үүрэг, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүргийг нарийвчлах;
- Эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж, давуу болон сул талыг эрэмбэлэх;
- Эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилт, уялдаа холбоо, нийтлэг асуудлыг судлах, хүрэх үр дүнг тооцох;
- Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлах;
- Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох;
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдааг харуулах.

**Стратеги төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим.** Төлөвлөгөөг "Ухаалаг" (SMART) буюу зорилго тодорхой байх (S-Specific), хэмжиж болохуйц (M-Measureable), зорилгодоо хүрч болохуйц байх (A-Attainable), бодитой байх (R-Relevant), цаг хугацаатай байх (T-Time based) зарчмуудыг агуулсан байхаар боловсруулахыг зорьсон.

**Төлөвлөгөөний хамрах хүрээ.** Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааг төлөвлөн 2021-2024 онуудад хэрэгжүүлэхээр тодорхойлов.

**Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн.** Энэхүү төлөвлөгөө нь Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааг цогц байдлаар төлөвлөсөн баримт бичиг юм.

Уг төлөвлөгөө амжилттай хэрэгжсэнээр эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэн, хууль зүйн салбарын бодлого, төлөвлөлтийн үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх болно.

## 1.1.ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-ний 1.1 дэх хэсэгт заасан салбарын өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, бодлого, зохицуулалтаар хангахын тулд яамны стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Иймд Хууль зүй, дотоод хэргийн яамны өмнө тулгамдсан асуудал нь салбарын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг бодлогын түвшинд тодорхойлох, хэрэгжүүлэх явдал юм.

## 1.2.СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.2-т "Төрийн албаны тухай хуулийн 53.1-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулан төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна." гэж заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилт, арга хэмжээнүүдийг 2021-2024 онд хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 156 дугаар тушаалаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн стратеги хөтөлбөр"-ийг хэрэгжүүлсэн хэдий ч үр дүнг нь тооцолгүйгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар хүчингүй болгож, харьяа агентлаг, байгууллагуудын стратеги төлөвлөгөөг чиглэл тус бүрээр нь баталсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/22 дугаар тушаалын хавсралтаар баталсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд суурилан яамны стратегийн чиглэл, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан гаргах хэрэгцээ шаардлага үүссэн.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний зорилтыг хангах шаардлагатай болсон. Засгийн газрын 2020 оны 95 дугаар "Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" тогтоолд зааснаар эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж, Сайд болон Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө өгөх, бүх талын дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн Хууль зүй, дотоод яамны 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулсан болно.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/22 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-ний мандатын шинжилгээ болон Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.3 дахь хэсэг "Яам нь Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ", 3.4 дэх хэсэг "Ерөнхий чиг үүргийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны нийт салбарын нийтлэг, чиглэлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны тодорхой салбарын асуудлаар энэ хуулийн 3.3.-т заасан чиг үүргийг тус тус хэрэгжүүлнэ" гэж тус тус заасныг үндэслэн мандатын шинжилгээг хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам нь эрх зүйн шинэтгэлийн **бодлогыг тодорхойлох,** түүнийг **хэрэгжүүлэх,** хэрэгжилтэд **хяналт шинжилгээ хийх,** үнэлгээ өгөх, **зөвлөгөө**, бүх талын **дэмжлэгээр** хангах замаар Сайд, Засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, удирдлагын зохистой хэлбэр төлөвшүүлэх буюу **удирдлагын төлөвлөх, зохион байгуулах, хянах, идэвхжүүлэх үндсэн чиг үүргийг** хэрэгжүүлнэ.




Салбарын мандатын шинжилгээгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлыг нийт 110 хууль, 24 олон улсын гэрээг хамарч, шууд хамаарах 28 хуулийн хүрээнд нарийвчлан тодорхойлсон нь Хууль зүй, дотоод хэргийн яамны мандатын шинжилгээнд ижил байхаар боловсруулсан.

Яамны чиг үүргийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний "**бодлогыг боловсруулах**", "**хэрэгжүүлэх**" гэсэн 2 ерөнхий чиг үүрэгт хувааж, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүрэг болгон дараах байдлаар нарийвчлан тусгалаа.

| | | | |
|---|---|---|---|
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хуулийн тоо | | 110 хууль, 24 олон улсын гэрээ | |
| Үүнээс | Тухайн салбарын хуулийн тоо | **82** | |
| | Нийтлэг мөрдөдөг хуулийн тоо | **28** | |
| **Ерөнхий чиг үүрэг-1: БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ** | | | |
| **Үндсэн чиг үүрэг** | | **Дэд чиг үүрэг** | **Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид** |
| | | *Хууль зүйн нэгдсэн бодлогыг төлөвлөх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, бодлогын уялдаа, мэргэжил, арга* | **ХЗБГ, ЗХХАХБХ,** |

<table>
<tr>
<td rowspan="4">УЧҮ-1: Төлөвлөх, бодлого тодорхойлох</td>
<td>зүйн зөвлөмжөөр хангах, захиргааны хэм хэмжээний актын бүртгэл, хяналтын эрхлэх үндсэн үүрэг хүлээх, хууль зүйн бодлогын хүрээнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах талаар судалгаа хийх, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх болон зардлын тооцоо хийх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төслийг боловсруулах, яамдаас боловсруулсан хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл Үндсэн хууль, бусад хуультай нийцэж байгаа эсэхийг хянах, санал өгөх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгох, Засгийн газрын шийдвэрийн төслийг хянах, төсөлд өгөх санал боловсруулах, захиргааны хэм хэмжээний акт батлахаар хуулиар тусгайлан эрх олгосон захиргааны байгууллагын шийдвэрийг хянах, бүртгэх, улсын нэгдсэн санд эрхлэн хөтлөх, олон нийтэд мэдээлэх, иргэд, байгууллагад лавлагаа, мэдээллээр үйлчлэх</td>
<td rowspan="4">ОУГТХАГ, МТГ, СХОГ ЛГХСГ, Яам, агентлаг, Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчийн газрууд</td>
</tr>
<tr>
<td>Хууль зүй, дотоод хэргийн салбарын эрхлэх асуудалд хамаарах асуудлаар олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох, хүний эрхийн хамгаалах зарим гэрээний хэрэгжилтийн тайланг боловсруулж, НҮБ-ын холбогдох гэрээний хороодод тайлагнах ажлыг зохион байгуулах, бусад яамдаас байгуулах хоёр талт олон улсын гэрээ болон нэгдэн орох олон талт гэрээнд санал өгөх, хууль зүйн дүгнэлт гаргах, гэрээний орчуулгыг хянах, гадаад улсын шүүх, олон улсын арбитрын ажиллагаанд оролцоход Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, эрүүгийн болон иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар гадаад улсын эрх бүхий байгууллага болон иргэд, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, гадаад улсуудтай гэмт этгээд болон ялтан шилжүүлэх асуудлаар хамтран ажиллах, эрх бүхий байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, яам, харьяа агентлаг, байгууллагын хоёр талт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд гадаад улсын ижил төрлийн байгууллагатай харилцах, байгууллага хоорондын гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх, олон улсын байгууллагатай харилцах, салбарын хэмжээнд гадаад орон болон олон улсын байгууллагын зээл, буцалтгүй тусламжаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</td>
</tr>
<tr>
<td>Хууль зүйн салбар дахь мэдээллийн технологийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, цахим засаг, инноваци, салбарын бодлогыг мэдээллийн технологиор дэмжих, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийн нэгтгэлийг хөгжүүлэх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, харьяа агентлаг, байгууллагуудын өгөгдлийн сан, мэдээллийн системийг нэгдсэн энтерпрайз архитектурын дагуу хэрэгжүүлэх, нээлттэй өгөгдлийг нэвтрүүлэх, харилцан мэдээлэл солилцох технологийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, яамны мэдээллийн технологийн талаар баримтлах нэгдсэн бодлого чиглэл, төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх, яамны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагддаг систем, програм хангамж, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хэвийн ажиллагаа, тэдгээрийн аюулгүй байдлыг хариуцах</td>
</tr>
<tr>
<td>Төсвийн ерөнхийлөн захирагчийн урт болон дунд хугацааны төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг төлөвлөх, салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлого, гадаадын болон олон улсын зээл тусламжийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлтийг макро болон микро эдийн засгийн орчин, салбарын нөхцөл байдалтай уялдуулан боловсруулах</td>
</tr>
<tr>
<td colspan="3">Ерөнхий чиг үүрэг-2: ХЭРЭГЖҮҮЛЭХ</td>
</tr>
<tr>
<td>Үндсэн чиг үүрэг</td>
<td>Дэд чиг үүрэг</td>
<td>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| УЧУ-2: Хэрэгжүүлэх, зохион байгуулах | Хууль тогтоомж болон салбарын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд харьяа байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг оновчтой тодорхойлоход дэмжин туслах, төлөвлөгөөг үйл ажиллагаатай холбоотой уялдуулах цаг, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх, холбогдох хөтөлбөр, төслүүдийн боловсролд хяналт тавих, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хороодын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, орон нутгийн хууль зүйн албадын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, хуульч, өмгөөлөгч, нотариатчийн өөрөө удирдах байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах | **ХЗЯ**: ЛДГ, ХХЕГ, ШШГЕГ, УБЕГ, ГИХГ, АЕГ, ОБГ, ШШҮХ, ДӨХС, ТТАХНЭ, ХЗҮХ, ХЗТТ, МХХ, МНТ, МӨХ |
| УЧУ-3:Хянан үнэлэх | Сайдын эрхлэх асуудлын хүрээний өөрчлөлт, байгууллага, яамны зохион байгуулалтын бүтцийн хэмжээнд үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх арга аргачлал боловсруулах, аргачлалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, хэрэглээний түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөндлөнгийн байгууллагаар хэрэгжүүлэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах; сайдын эрхлэх асуудлын хүрээний өөрчлөлт, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх; салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, салбарын төвлөрсөн бүртгэл статистик мэдээллийг эрхлэн хөтлөх; хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх, яамны удирдлагын бодлогын зөвлөмжөөр хангах | **ХШҮДАГ**: ЛДГ, ХХЕГ, ШШГЕГ, УБЕГ, ГИХГ, АЕГ, ОБГ, ШШҮХ, ДӨХС, ТТАХНЭ, ХЗҮХ, ХЗТТ, МХХ, МНТ, МӨХ, ГХҮСАЗЗ |
| УЧУ-4: Идэвхжүүлэх, дэмжих | Төрийн захиргаа, хүний нөөцийн менежментийг хангах, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсронгуй болгох, хяналт тавих, тайлагнах, яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн баталгааг хангах, дотоод болон мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах; иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах; салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх; хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах, үр дүнг нь тооцох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хууль зүйн боловсрол, эрх зүйн сургалт, сурталчилгааны талаарх бодлогын хэрэгжилтийг зохицуулах, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах | **ТЭҮГ, ЭЗК, СХБГ, ХОТХ** ЛДГ, ХХЕГ, ШШГЕГ, УБЕГ, ГИХГ, АЕГ, ОБГ, ШШҮХ, ДӨХС, ТТАХНЭ, ХЗҮХ, ХЗТТ, МХХ, МНТ, МӨХ, СЯ ҮАГ(үндэсний аудитын газар), (Сангийн яам), ТӨБЗГ) |
| | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үйлдэл, харьяа байгууллагын зардлын төсвийг хариуцлагатай бэлтгэх, тайлагнах, барих, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах, төрийн өмчийн бүртгэл, хяналт, төрийн сангийн төлбөр тооцоо, нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлагнал, аудит, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, салбарын албан хаагчдын нийгмийн асуудал, харьяа төсөвт хэмжээний мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, яамны санхүү, эд хөрөнгийн үйл ажиллагааг төвлөрсөн хөтлөх | |

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА-VISION

Шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан хуулийн засаглалыг бэхжүүлнэ.

## ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО-MISSION

Хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх, ашиг сонирхлыг хадгалан хамгаалахад чиглэсэн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэн, гадаад дотоод хүчин зүйлсийг нөлөөллийг харгалзан тулгарч буй сорилт бэрхшээлийг эерэг үр дүнд тэмүүлсэн хэлбэрээр даван туулах ТЭРГҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА болон хөгжихэд оршино.

## ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Техник технологи, мэдээ мэдээллийн хурдацтай хөгжилтийн эрин зуунд нийгэмдээ илүү сайн дасан зохицож, бусдаас нэг алхамаар илүү сэтгэж, ирээдүйн өөрчлөлтийн талаар баримжаатай байж, түүнд зориулсан зорилго, төлөвлөгөөтэй байх нь энгийн шаардлага юм.

Хууль зүй, дотоод хэргийн яамны SWOT шинжилгээг хийхдээ дотоод хүчин зүйлд давуу талыг илэрхийлэх 3, сул талыг илэрхийлэх 3, гадаад хүчин зүйлсийн таатай нөхцөлийг илэрхийлэх 3, таагүй нөхцөлийг илэрхийлэх 3 гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан.

СВОТ(SWOT) шинжилгээ хийсний дараа цуглуулсан мэдээллэл дээрээ тулгуурлан дараагийн алхам болох ТОВС(TOWS) шинжилгээ хийв.

TOWS шинжилгээ нь дотоод давуу болон сул талууд, гадаад боломж, аюул заналхийллийг үнэлж дүгнээд цаашид баримтлах стратегиудыг 2 X 2 матрицаар харуулдаг.

Ийнхүү гадаад, дотоод хүчин зүйлсийг нягтлан тодорхойлж, үнэлгээний үр дүнд яамны үйл ажиллагаа бүрийн зорилго, хэрэгжүүлэх стратегийг дараах байдлаар тодорхойлно:

SO - шийдвэр: давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг дээд зэргээр ашиглах стратеги;

WO - шийдвэр: сул талыг сайжруулан гадаад орчны таатай боломжийг дээд зэргээр ашиглах стратеги;

ST- шийдвэр: давуу талд тулгуурлан гадаад орчны таагүй нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах стратеги;

WT - шийдвэр: гадаад орчны таагүй нөхцөлд салбарын сул талаа сайжруулах замаар гарах сөрөг үр дагаврыг аль болох багасгах стратеги.

## 5.1.SWOT шинжилгээний үр дүн, баримтлах стратеги:

**TOWS матриц**

<table>
<tr><td colspan="2" rowspan="2">Хууль зүй, дотоод хэргийн яам</td><td colspan="2">ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС</td></tr>
<tr><td>Давуу тал-S<br>-Эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлсэн;<br>-Цахимжуулалтын ажлыг эхлүүлсэн;<br>-Төрийн үйлчилгээг шуурхай явуулдаг.</td><td>Сул тал-W<br>-Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж "дунд" түвшинд байдаг;<br>-Албан хаагчдын ажлын ачаалал жигд бус;<br>-Хүний нөөцийн хөдөлгөөн их.</td></tr>
<tr><td rowspan="2">ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛС</td><td>Таатай нөхцөл-O<br>-Засгийн газрын бодлого чиглэл, түүнийг хэрэгжүүлэх арга зам тодорхой;<br>-Үйл ажиллагаандаа удирдлага болгох хууль, дүрэм, журмын хэрэгжилт сайн;<br>-Гадны байгууллагын дэмжлэг туслалцаа авах боломж их.</td><td>SO-Давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг ашиглах стратеги:<br>-Хууль зүйн нэгдсэн бодлогыг хууль зүйн шинжлэх ухаан, онолын чиг хандлагад нийцүүлэн тодорхойлох, Монгол Улсын хууль тогтоомжуудын харилцан уялдааг хангах.</td><td>WO-Сул талыг сайжруулан гадаад орчны таатай боломжийг ашиглах стратеги:<br>-Олон улсын эрх зүй болон сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;<br>-Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, байгууллагын үнэт зүйлийг бэхжүүлэх.</td></tr>
<tr><td>Таагүй нөхцөл-T<br>-Улс төр, нийгмийн амьдрал тогтвортой бус;<br>-Нийгэм, эдийн засгийн сул байдал, ядуурал, ажилгүйдэл, шилжилт хөдөлгөөн зэргийн нөлөөлөл их;<br>-Иргэдийн хуулийн мэдлэг, харилцааны соёлоос шалтгаалан үл ойлголцол үүсэх.</td><td>ST-Давуу талд тулгуурлан гадаад орчны таагүй нөлөөг даван туулах боломжийг ашиглах стратеги:<br>-Хууль зүйн боловсрол, эрх зүйн сургалтын бодлогыг тодорхойлон төлөвшүүлэх;<br>-Хууль зүйн салбарын оновчтой, чадварлаг бүтцийг хөгжүүлэх;<br>-Салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих.</td><td>WT-Гадаад орчны таагүй нөхцөлд сул талаа сайжруулах замаар сөрөг үр дагаврыг даван туулах стратеги:<br>-Нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх;<br>-Байгууллагын хүний нөөцийн болон санхүүгийн чадавхыг бэхжүүлэх.</td></tr>
</table>

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

**6.1.Стратегийн зорилго**

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратегийн зорилго нь эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэн, хууль зүйн салбарын бодлого, төлөвлөлтийн үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэхэд оршино.

**6.2.Стратегийн зорилт**

Хууль зүй, дотоод хэргийн яам нь стратегийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

6.2.1.Эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.

6.2.2.Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

6.2.3.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

6.2.4.Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, зохицуулан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлнэ.

6.2.5.Бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх замаар удирдлагыг мэдээллээр хангах эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлнэ.

6.2.6.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна.

6.2.7.Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон шууд захирагчийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, зохион байгуулах замаар санхүүгийн сахилга батыг сайжруулна.

## ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

Хууль зүй, дотоод хэргийн яам нь стратегийн зорилтоо дараахь шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, стратегийн хүрээнд хэрэгжүүлнэ:

| | | |
|---|---|---|
| ***Төлөвлөгөөг баталсан:*** | | ***Төсвийн ерөнхийлөн захирагч*** |
| ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД | ........................ | /Х.НЯМБААТАР/ |
| */Албан тушаал/* | */Гарын үсэг/* | */Он, сар, өдөр/* |
| *Тэмдэг* | | ........2021.03.16........ |
| ***Төлөвлөгөө боловсруулсан:*** | | ***Төрийн нарийн бичгийн дарга*** |
| ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА | ........................ | /Б.БААСАНДОРЖ/ |
| */Албан тушаал/* | */Гарын үсэг/* | */Он, сар, өдөр/* |
| *Тэмдэг* | | ........2021.03.16........ |

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ "2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ"

| Бодлогын баримт бичигт тусгагдсан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН НЭР: | | | | | |
| НЭГ. БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ | | | | | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН НЭР: | | | | | |
| *Нэг.Бодлого төлөвлөх, тодорхойлох* | | | | | |
| 1.3х газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ. | 1.1.Хууль хоорондын уялдааг нэгдсэн бодлогоор хангах зорилгоор нийтлэг харилцааг зохицуулсан хуулийн төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх. | Хамтран боловсруулсан хуулийн төслийн тоо | 0 | 2 | Улсын төсөв Бусад эх үүсвэр |
| | 1.2.Хууль зүйн бодлогын судалгаа хийх, хуулийн хэрэгжилтийг үнэлэх. | Судалгааны болон үнэлгээний тайлан | 0 | 1 | Улсын төсөв |
| | 1.3.Хууль тогтоомжийг сурталчлах, хүртээмжийг нэмэгдүүлэх. | Иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг тухай бүр нь сурталчилсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 1.4.Захиргааны хэм хэмжээний актын бүртгэл хяналтын тайлангийн цахим системийг боловсруулах | Цахим сантай болсон эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 1.5.Орон тооны гишүүдээс бүрдсэн Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороог байгуулах замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлж, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа | Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 5 | Улсын төсөв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох | | | | |
| | 1.6.Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгааллалтыг сайжруулж, бизнес эрхлэх таатай орчныг дэмжсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох. | Анхдагч хуулийн төсөл болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 11 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 1.7.Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх эрх зүйн орчныг бүрдүүлах. | Анхдагч хуулийн төсөл, хуулийн шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 2 | Улсын төсөв |
| | 1.8.Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгох замаар эрх зүйн орчныг сайжруулах | Хуулийн шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 8 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 1.9.Үндсэн хуулийн цэц болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 2 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 1.10."Эрх зүйн шинэтгэл II" хөтөлбөрийг боловсруулах | "Эрх зүйн шинэтгэл II" хөтөлбөрийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 1 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 1.11.Хууль зүйн туслалцаа авах хүрээг өргөжүүлэх замаар хууль зүйн туслалцааны эрх зүйн орчныг сайжруулах | Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 1.12.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг сайжруулах | Шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 1 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 1.13.Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ хязгаарыг тодорхой болгох, Хууль тогтоомжийн тухай хуулийг боловсронгуй болгох | Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 1 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 1.14.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 1 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 1.15.Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 7 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 1.16.Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах | Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 1.17.Цахим шинэчлэлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулах | Шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 3 | Улсын төсөв |
| | 1.18.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, хууль хоорондын уялдаа холбоог хангах | Шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 0 | 8 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| 2.Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 2.1.Гадаад орнуудтай эрүү, иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх эрх зүйн орчныг өргөжүүлэн хөгжүүлэх | Олон талт болон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх | 36 | 41 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2.2.Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах, Монгол Улс нэгдэн орсон хүний эрхийн чиглэлээрх конвенцид заасан Монгол Улсын хүлээсэн үүргийн хэрэгжилтийн судалгаа хийх | Судалгааны тайланг хэлэлцүүлсэн эсэх | 0 | 1 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 2.3.Эстийн газарт холбогдох олон улсын арбитрын маргаанд Засгийн газрыг төлөөлж оролцох зохион байгуулалтын бүтцийн нэгжийг бий болгох | Арбитрын маргаан хариуцсан нэгж байгуулагдсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 2.4.Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх | Арга хэмжээ зохион байгуулсан эсэх, баримт бичиг байгуулсан эсэх | 0 | 4 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| | 2.5.Олон улсын байгууллагын болон гадаад орны зээл, буцалтгүй тусламжийн төсөл, хөтөлбөрийн санал хүргүүлэх, хэрэгжүүлэх, уялдааг хангах | Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, төсөл, хөтөлбөрүүдийн хоорондын уялдааг хангаж, Сангийн яам болон холбогдох олон улсын байгууллага, гадаад улсаас санал, зөвшөөрөл авсан эсэх | 7 | 9 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |
| 3.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шилжилтийг хэрэгжүүлнэ | 3.1.Салбарын үйлчилгээг цахимжуулах | Үйл ажиллагаа цахимжуулсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 3.2.Салбарын дотоод үйл ажиллагааг цахимжуулах | | | | |
| | 3.3.Хууль зүйн салбарын нэгдсэн мэдээллийн дэд бүтцийг бий болгох | Мэдээллийн дэд бүтцийг бий болгосон эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 3.4.Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын талаар баримтлах нэгдсэн бодлого чиглэл, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Боловсруулсан хөтөлбөрийн тоо | 0 | 5 | Улсын төсөв |
| 4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон шууд захирагчийн хэрэгтэй | 4.1.Салбарын урт болон дунд хугацааны хөгжлийн оруулалтын бодлогыг боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. | Төлөвлөгөө боловсруулсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв, Бусад эх үүсвэр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| оруулалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, зохион байгуулах замаар санхүүгийн сахилга батыг сайжруулна. | 4.2.Салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, салбарын хэмжээнд санхүү бүртгэлийн сахилга батыг хангуулах ажлыг зохион байгуулах | Бодлогын баримт бичиг боловсруулсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | | Зохион байгуулсан ажлын тоо | 0 | 8 | |
| | 4.3.Салбарын санхүү бүртгэлийн нэгдсэн програм хангамжийг боловсруулах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, Монгол Улсын цахим санхүү бүртгэлийн жишиг салбар болох | Боловсруулсан програм хангамжийн тоо | 0 | 1 | Улсын төсөв, бусад эх үүсвэр |
| | | Зохион байгуулсан ажлын тоо | 0 | 8 | |
| **ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН НЭР:** | | | | | |
| **НЭГ. ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | |
| **ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН НЭР:** | | | | | |
| ***Хоёр.Хэрэгжүүлэх, зохион байгуулах*** | | | | | |
| 1.Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, зохицуулан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлнэ. | 1.1.Хууль тогтоомж болон салбарын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, энэ талаар холбогдох бусад байгууллага, орон нутгийн хууль зүйн албадын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан сургалтын тоо /Жил бүр/ | 1 | 4 | Улсын төсөв |
| | | Салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан эсэх /Жил бүр/ | 1 | 4 | |
| | 1.2.Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын стратегийг тодорхойлж, хэрэгжилтийг зохицуулан, нэгдсэн удирдлагаар хангах | Стратеги төлөвлөгөө боловсруулсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 1.3.Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан иргэн, | Өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэж ажилласан эсэх /Жил бүр/ | 1 | 4 | Улсын төсөв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | | | | |
| | 1.4.Хуульч, өмгөөлөгч, нотариатчийн өөрөө удирдах ёсны байгууллагыг арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллах | Мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байдал /Жил бүр/ | 1 | 4 | Улсын төсөв |
| | 1.5.Хуульд заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой бодлогын хэрэгжилтийг хангах, харьяа агентлаг, байгууллагад дэмжлэг үзүүлэх | Тусгай зөвшөөрөл олгох болон дэмжлэг туслалцаа үзүүлж ажилласан байдал /Жил бүр/ | 1 | 4 | Улсын төсөв |
| | 1.6.Харьяа агентлаг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулах, биелэлтийг үнэлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо /Жил бүр/ | 12 | 48 | Улсын төсөв |
| ***Гурав. Хянан үнэлэх*** | | | | | |
| 1.Бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх замаар удирдлагыг мэдээллээр хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлнэ. | 1.1.Салбарын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх журам, аргачлал боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Журам, аргачлал шинэчлэн боловсруулсан эсэх | 0 | 2 | Улсын төсөв |
| | 1.2.Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, зорилгод хүрч байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан /нэгдсэн тоо, жилээр/ | 1 | 4 | Улсын төсөв |
| | | Хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн хэрэглэгчийн үнэлгээний тайлан | 1 | 4 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 1.3.Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх | Дотоод аудит хийсэн тайлан | 3 | 12 | Улсын төсөв |
| | 1.4.Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх | Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээний тайлан | 1 | 4 | Улсын төсөв |
| | | Салбарын төвлөрсөн бус статистик мэдээлэл /сар бүр/ | 12 | 48 | |
| | 1.5.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх | Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дагаварт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| ***Дөрөв.Идэвхижүүлэх, дэмжих*** | | | | | |
| 1.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна. | 1.1.Төрийн захиргаа, хүний нөөцийн манлайллыг хангах, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, хяналт тавьж тайлагнах | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайлан /жилээр/ | 1 | 4 | Улсын төсөв |
| | | Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо | 1 | 4 | |
| | 1.2.Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих | Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | 92 | 100 | Улсын төсөв |
| | 1.3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах | ХАСУМ цахимаар мэдүүлсэн албан хаагчийн тоо | 109 | 436 | Улсын төсөв |
| | 1.4.Салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн | Баримт бичиг боловсруулсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | баталгааг сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх | | | | |
| | 1.5.Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлах ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах | Төлөвлөгөөг батлуулсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 1.6.Аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах, үр дүнг нь тооцох ажлыг зохион байгуулах, зохицуулах | Гэрээний тоо | 22 | 88 | Улсын төсөв |
| | 1.7.Эрх зүйн сургалт, сурталчилгааны талаарх бодлогын хэрэгжилтийг зохицуулах | Төлөвлөгөө боловсруулсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | 1.8.Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах | Төлөвлөгөө боловсруулсан эсэх | 0 | 1 | Улсын төсөв |
| | | ХМХ-тэй харилцах ажлыг зохион байгуулсан эсэх | 0 | 1 | |
| | 1.9.Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр, яамны эгээс бусад байгууллагатай байгуулах гэрээний эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах | Эрх зүйн үндэслэл хангагдсан байдал | 0 | 1 | Улсын төсөв |
| 2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон шууд захирагчийн хөрөнгө оруулалтын бодлогыг | 2.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах | Төсвийн гүйцэтгэлийн хувь | 95 | 99.2 | Улсын төсөв |
| | 2.2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах | Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувь | 94.5 | 99.2 | Улсын төсөв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, зохион байгуулах замаар санхүүгийн сахилга батыг сайжруулна. | 2.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн өмчийн бүртгэлд хяналт тавих, тайлагнах | Саналын шийдвэрлэлтийн хувь | 98.8 | 100 | Улсын төсөв |
| | 2.4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн төлбөр тооцоог хийх | Алдаа, зөрчлийн тоо | 64 | 48 | Улсын төсөв |
| | 2.5.Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлагнал | Зөрчил, акт, албан шаардлагын тоо | 103 | 90 | Улсын төсөв |
| | 2.6.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 93 | 99.2 | Улсын төсөв |
| | 2.7.Салбарын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх | Баригдсан орон сууцны тоо | 773 | 840 | Улсын төсөв |
| | | Дэмжлэг үзүүлсэн албан хаагчдын тоо | 21 | 24 | |
| | 2.8.Ямны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах | Алдаа, зөрчлийн тоо | 1 | 0 | Улсын төсөв |

## НАЙМ.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамны зохион байгуулалтын бүтцийг Засгийн газрын "Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 2020 оны 95 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон.

Салбарын стратеги төлөвлөгөө нь бодлогын баримт бичигт заасан салбарын зорилгыг хэрэгжилт, хууль зүйн салбар, тус яамны бүтцийн уялдаа, зураглалыг тусгасан тул Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-ний 8 дахь хэсэгт заасныг мөн нэгэн адил баримтлана.

------- oOo ------


АЛСЫН ХАРАА 2050
МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ
ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР
ХЭДХС-ЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
ХЭДХЯ-ны СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ
БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ
ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ
ЦЕГ
Иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага
Яам, Засгийн газрын агентлаг, байгууллагууд
Шүүх, Прокурорын байгууллага, МНТ

## ЕС.ХАВСРАЛТ

9.1. Мандатын шинжилгээ

9.2. Эрсдэлийн үнэлгээ

9.3. Хэрэглэгчийн үнэлгээ

9.4. Төсвийн төлөвлөлт

-------- oOo -------